

ТҮҮХЭН ХҮН АМ ЗҮЙ

Ж.Урангуа

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүлэлийн товч агуулга: Түүхэн хүн ам зүйн ухааны тухай товч ойлголт, түүний хөгжилт. Хүн ам зүйн судалгаа болон түүхэн судалгааны харилцан нөхцөлт. Түүхэн хүн ам зүйн ухааны эх сурвалжууд. Монгол улс дахь хүн ам зүйн судалгааны байдал

Түлхүүр үгс: Хүн ам зүйчид ба түүхчид, түхэн хүн ам зүй, Монгол Улс дахь түүхэн хүн ам зүй

Түүхэн хүн ам зүй нь түүхийн шинжлэх ухаан болон хүн ам зүйн шинжлэх ухааны бэлчээр уулзвар дээр үүссэн бөгөөд хүн амын нөхөн үржихүйн түүхэн явцыг нийгэм-эдийн засаг, соёл, байгалийн цогц өргөн цар хүрээнд авч судалдаг юм.

Манай эриний хүн ам зүй судлаач францын нэртэй эрдэмтэн А.Ландри бодит баримт судлах нь хүн ам зүй судлалын анхдагч зорилт мөн гэж тодорхойлсноор түүх судлалын асуудалд эргэн хандах явдал онцгой ач холбогдолтой болохыг тэмдэглэн үлдээсэн нь гайхамшигтай ажгуу. Үүнээс гадна энэхүү зорилтыг шийдвэрлэхэд түүний үзэж буйгаар хүн ам зүй түүхэн үүрэг гүйцэтгэнэ. Эрдэмтэн хүний хувьд тэрбээр мэдээж түүх болон хүн ам зүй гэсэн хоёр шинжлэх ухааныг адилтган үзээгүй, харин хүн ам зүй нь түүхэн тасралтгүй явц гэсэн санаа дэвшүүлсэн юм. Чухам энэ л асуудал хүн ам зүйг түүхтэй холбон үзэхэд эрэлт хэрэгцээтэй болсон тэдгээрийн өнгөрсөн цаг үе тийш хандсан ретроспектив үзлийг байнга судлах шаардлагатай болгож байна. Хэдэн жилийн дараа түүний шавь А.Сови шинжлэх ухааны орчин цагийн эрэлт хэрэгцээнээс үүдэн энэхүү асуудлыг илүү өргөн цар хүрээнд тавьсан бөгөөд тэрбээр хүн ам зүйд түүхчдийн анхаарлыг илүү үр нөлөөтэй хандуулан татах шаардлагатай болохыг хэлж байсан амуй.

Гэвч түүх болон хүн ам зүй судлал гэсэн хоёр шинжлэх ухааны харилцан хамаарлын энгийн магадлан тэмдэглэх констатаци үзэл дан ганц байгаа нь хангалтгүй. Тэдгээрийн харилцан уялдаа холбоотой байх явдал автоматаар хэрэгжих бус харин хүн ам зүйн шинжлэх ухааны системд түүхэн хүн ам зүйн асуудлуудын байр суурийг тодорхой тогтоож, гүн гүнзгий дүн шинжилгээ хийн, ухамсарлан ойлгохыг шаарддаг байна. Өөрийн судлах объект “хүн ам” – ын хувьд уг шинжлэх ухаан түүхийн шинжлэх ухааны салбарт хамаардаг хэдий ч түүний судлагдахуун зүйлчлэх салбар нь хүн ам зүйн түүх судлалын тодорхой агуулгыг тодорхойлогч зүйл нь хүн ам зүй судлалаас бүрэлдэн тогтож, хүн ам зүй судлалд хэрэглэгддэг арга хэрэгсэл, аргачлалын тусламжтай судлагддаг, түүнчлэн тоймлож байгаз асуудлын түүхэн өнгөрсөн үед дэх проекц тусгал мөн гэж хэлж болно. Түүхэн хүн ам зүй судлал иймээс хоёр шинжлэх ухааны холимог салбар ухаан юм. Тэдгээрийн харилцан холбооны хөгжил, харилцан уусах байдал энэ түүхэн судлалын зайлшгүй нөхцөл болоод зогсохгүй мөн энэхүү хоёр шинжлэх ухаанд олсон үр дүнгийн задлан шинжлэл болон интеграци цомтгох явдалд шилжих байдлыг хангаж, орчин цагийн практик зорилтуудыг төдийгүй олон талаас түүхэн хөгжлөөр тодорхойлогдох хүн амын нөхөн үржихүйн зорилтуудыг шийдвэрлэхэд тус дэм болдог.

Түүхэн мэдлэг, хүн ам зүйн төсөөлөл таамгийн эх үүсвэрүүдийн харилцан холбоо орчин үеийн нийгэм судлалын үндэс суурь тавигдаж эхэлж байсан эхний үе шатанд илэрсэн юм. XVII зууны хоёрдугаар хагаст хамаарах Английн “улс төрч арифметикчид” сүүлийн үед хүн ам зүйн явц хэмээн нэрлэгдэх болсон үзэгдлүүдийг судлах асуудлыг анх хөндсөнөөр хүн амын тухай түүхэн

мэдээллийн үндсэн дээр өөрсдийн нээлтүүдийг хийсэн билээ. Тэдний үзэл бодлын талбарт цаг хугацааны томоохон хэсэгт хамаарах нас баралтын мэдээ баримт орсон явдал урт удаан хугацааны явцад өнгөрсөн үеийн нас баралтын явцыг анх удаа ажиглах боломж олгосон юм. Ийм өгөгдлийн мэдээлэлтэй болсон нь манай цаг үед ч тодорхойлогч хүчин зүйл болж байна. Учир нь онцгой эрч хүч агуулснаар хүн ам зүйн явц, үе удам солигдох байдал тэдгээрийг судлах, тэдгээрт орох өөрчлөлтийн зүй тогтлыг илрүүлэхэд он удаан цаг хугацаа шаардлагатай байдаг. Ийм л учраас хүн ам зүйн хувьд: ерөнхийдөө, түүний дотор хүн ам зүйн онолд түүхэн талаас хандах нь чухал ач холбогдолтой ажээ. Хүн ам зүйн явцыг амжилттай судлах нь зөвхөн "тухайн хугацаанд" хамаарагдах материалд тулгуурлан судлах боломжгүй зүйл ба судалгаанд тэдгээрийн түүхэн цаг үеийг эргэн харах ретроспектив хандлага байхыг бараг цаг үргэлж шаардана.

Гэхдээ, мэдээж, зөвхөн энэ байдал хүн ам зүйд түүх рүү хандахыг тодорхойлохгүй. Хүн ам зүйн бүх явц зүгээр л түүхэн үйл явдлын өнгө, дэвсгэр дээр судлагддаг гэдгээр хязгаарлагдахгүй. Тэдгээр нь "хана, дэвсгэр" дээр бус харин түүхэн хөгжлийн контекст, тухайн орчинд түүний органик бүрэлдэхүүн хэсэг болон судлагдана. Хүн ам зүйн шинжлэх ухааны үндсэн зорилт бол хүн амын нөхөн үржихүйн зүй тогтлыг түүний нийгэм болон байгалийн нөхцөл байдалд нээн илрүүлэх явдал ба энэхүү нөхөн үржихүйн асуудлыг түүхэн явц, түүхэн хөгжлийн агуулгад холбон авч үзсэний үндсэн дээр зөвхөн хэрэгжих боломжтой юм. Үүний хүчинд хүн ам зүй өөрийн гэсэн баталгаа гаргах тусам илүү их шинжлэх ухаанч болж өөрийн судалгаануудад түүхийн эх сурвалжууд болон хүн ам зүйн материалд тулгуурласан түүхэн зүйн зарчимд үндэслэгдсэн судалгааны ажил явуулах болсон амуй.

Орчин үеийн түүх-хүн ам зүйн судалгаанууд мэдээж хэрэг хоосон орон зайд үүсэн буй болоогүй, харин өмнөх үед хийгдэж байсан хүн ам зүйн түүхэн судалгааны үргэлжлэл болсон юм. Гэхдээ ХХ зууны 50-аад оноос эхлэн түүхэн хүн ам зүйн судалгаанд томоохон өөрчлөлтүүд гарч, тухайн асуудлаар хийсэн судалгааны ажлын тоо хэмжээ ихээхэн өсөн нэмэгдэх байдлаар илэрснээс гадна хүн ам зүйн анализ шинжилгээнд гарсан ололт амжилтыг идэвхитэй ашигласны үндсэн дээр арга зүйг улам боловсронгуй болгож, судлагдаж буй үйл явцын мөн чанарт нэвтрэн орох, тэдгээрийг тайлбарлах оролдлого хийх байдлаар ил тод болсон юм.

Түүхэн хүн ам зүйн хөгжлийн шинэ үе шатанд шилжих явц ХХ зууны 50-аад оны үед үндсэндээ хийгдэж эхэлсэн байна. Түүхэн хүн ам зүйн хөгжил хүн амын асуудалд өсөн нэмэгдэж буй сонирхлын илрэл болсон төдийгүй түүний нөхөн үржихүйн асуудал хүн амын тоо буурахтай холбогдон барууны орнуудад төрийн зүгээс баримтлах бодлого болон хувирч, харин буурай хөгжилтэй улс оронд хүн амын тоог эрс өсч байгаа байдлыг зохицуулахад чиглэсэн бодлоготой холбоолтой. Түүхэн хүн ам зүйд хандуулсан анхаарал иймээс түүхэн явцад орчин цагийн хүн ам зүйн явцад тайлбар өгөх хүсэл эрмэлзэл төрүүлж, мөн түүнчлэн хөгжилтэй нийгмийн түүхэнд хөгжингүй орнуудын хүн ам зүйн эволюц хөгжилтэй адил төстэй талуудыг олох оролдлого хийхэд хүргэсэн байна. Өөр нэг тал нь тухайн үед хүн ам зүйн өөрчлөлтөнд гарсан эдийн засаг, нийгмийн аспектыг сонирхох байдал өсөн нэмэгдэж байсантай холбоотой. Түүхэн материалд тулгуурлахгүйгээр хүн ам зүйн хүчин зүйлийн нөлөөг эдийн засаг, нийгмийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлэх байдлыг ретроспектив хуучин үе рүү эргэн харах задлан шинжилгээ хийхгүйгээр орчин үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм. Орчин үед түүхэн хүн ам зүйг сонирхох явдал мөн хүн ам зүйн судалгааны аргачлалын хөгжлийн ололт амжилтаар бэлтгэгдсэн байлаа.

Түүхэн хүн ам зүйн тодорхой судалгаа нь өөр хоорондоо харилцан холбоотой гурван үндсэн чиглэлийг нөхцөлдүүлж байдаг. Тэдгээрийн нэгдүгээрт, хүн амын тооны динамик хөгжлийн эволюц түүхэн явцын судалгаа, түүний бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт, хүн амын тархалт, нягтрал мөн түүнчлэн шилжих хөдөлгөөн хамаарна. Хүмүүсийн шилжих хөдөлгөөн, тархалтыг мөн түүнчлэн түүхэн газарзүй судалдаг билээ. Гэхдээ түүхэн хүн ам зүй эдгээр асуудлуудын ард бие даасан сонирхлоо хадгалан үлдэх ба тэдгээр нь тодорхой хэмжээнд хүн амын тоонд болон тодорхой нутаг дэсвгэрийн хүрээнд хүн амын нөхөн үржихүйн явцад нөлөөлдөг.

Хүн ам зүйн түүхэн эволюц хөгжлийн олон талт задлан шинжилгээ нийгэм, байгалийн нөхцөлд түүхэн хүн ам зүйн хоёр дахь чиглэл болж түүний гол тулгуур болдог гэж хэлж болно. Төрөлт, нас баралт, хүйсийн харьцаа, хүн амын нөхөн үржихүйн түүхэн төрөл зүйл солигдох байдал орчин цагийн хүн ам зүйн явцын задлан шинжилгээнд төдийгүй мөн хүн ам зүйн бодлогын арга замыг тодорхойлох, боловсронгуй болгох, таамаглах зорилгоор ашиглахад хамгийн их практик ач холбогдолтой. Нийгмийн үзэгдлийн нэгэн хэлбэр болхын хувьд гэрлэлт, ам бүл, хүн ам зүйн ачаалал, хүн амын төлөв байдлыг судлахад түүхэн хүн ам зүй нь түүхэн сэтгэл судлал, түүхэн социологи, угсаатан судлал болон анагаах ухааны хэд хэдэн салбар ухаантай холбогдоно.

Гурав дахь чиглэл- хүн ам зүй хөгжлийн түүхэн явцыг илрүүлэн нээх зорилгыг шийдвэрлэхтэй холбоотой байхын зэрэгцээ хүн ам зүйн хүчин зүйлсийн түүхэнд гүйцэтгэх үүрэг ролийг тодорхойлно. Энэ нь онолын боловсруулалтыг тодорхой түүхэн судалгаануудтай уялдуулан холбохыг шаарддаг. Тухайлбал: нийгмээс хүн ам зүйд нөлөөлөх байдлыг судлах, түүний дотор хүн ам зүйн бодлогын элементүүд эрт цаг үеэс орчин цаг хүртэлх түүхийн хугацаанд бүхий л талаар илрэх байдал хамаарна.

Түүхийн судалгааны ном зохиолд он удаан жилийн туршид зөвхөн хүн амын тоо, нягтралын хүчин зүйлс л анхаарал татаж байлаа. Гэтэл өнөө үед хүн ам зүйн бүхий л үзэгдэл, явцын нэгдлийг бүрэн хэмжээнд судлах асуудал чухлаар тавигдаж байгаа билээ. Ингэхийн тулд "хүн амын хөгжлийн" хүн ам зүйн ерөнхий онолын шинжлэх ухааны ангилалыг түүхчид боловсруулан гаргах шаардлагатай байгаа билээ. Энэ л аспектад чухам одоо цагт хүн ам зүйн хүчин зүйлсийг зөвхөн тоон илрэлээр бус мөн хүн ам зүйн түүхэн явцын эволюц хөгжлийн хүрээнд болон бүтцэд хүн амын хөгжлийн органик бүрэлдэхүүн хэсэг ба ердийн түүхэн явц гэж үзэх оролдлого хийгдсэн байна. Харамсалтай нь энэ чиглэлд одоохондоо судалгааны ажил бага явагдаж байгаа ч энэ төрлийн судалгаа хийх нь орчин цагийн түүхэн хүн ам зүйн үндсэн асуудлын нэг чухал зүйл болж байгаа нь илт байна.

Түүхэн хүн ам зүйд он цагийн хүрээнд асуудлыг авч үзэж судлах явдал онцгой ач холбогдолтой. Түүхэн хүн ам зүй өөрийн судалгааны объектыг түүх-нийгмийн явцын туршид, эртний цаг үеэс өнөөдрийг хүртэл хамарч судалдаг. Тиймээс түүхийн шинжлэх ухааны нэг гол зарчим, арга зүйн хандлага болох Түүхэн зүйн зарчим түүхэн хүн ам зүйд амин сүнс нь болдог.

Өрнөдийн хүн ам зүйчид түүхэн хүн ам зүйн эх сурвалжийг үндэслэн түүхэн хүн ам зүйг гурван үе болгон хуваан үздэг. Үүнд: бичиг үсэг гарахаас өмнөх үе, статистик тооцооноос өмнөх үе болон статистикийн үе.

Түүхэн хүн ам зүйн эх сурвалжууд ихээхэн онцлогтой байдаг ба энэ нь хүн ам зүй судлаачид төдийгүй түүхчидтэй хамтран судлах тусгай судалгааны ажлыг шаарддаг. Үүнд, тухайлбал, хүн ам зүйн судалгааны орчин үеийн аргачлал ашиглахад орших ба хүн амын тухай түүхэн баримт материал дутагдалтай эсвэл бүрэн бус байгаа нөхцөлд үнэн зөвийг магадлан шалгах, бүрэн болгоход чиглэгдэнэ. Сүүлийн үед түүхэн хүн ам зүйн судалгааны

талбарт түүхчид болон зүйн ам зүйчдын шинжлэх ухаан-практик хамтын ажиллагааны асуудал улам бүр анхаарал татаж байна. Учир нь түүхчид түүхэн хүн ам зүйн судалгааны аргачлалыг чадмаг эзэмшсэнээр өөрийн гарт буй сурвалжийн хүрээнд судлан буй үеийн түүхэн хөгжлийн дүр зургийг сэргээн гаргах боломж нээгдэнэ.

Манай эх оронд түүхэн хүн ам зүй судалгаа эх үүсвэрийн төдий байгаа хэмээн хэлхэд хилсдэхгүй болов уу. Энэ нь юуны түрүүнд манай оронд албан ёсны статистик тоо бүртгэл харьцангуй хожуу үүссэнтэй холбоотой юм. Хүн амын орчин үеийн тооллогын түүх харьцангуй богино боловч хүний нийгэм үүсэн цагаас хойш улс гүрэн хүн амаа бүртгэн тоолж байсан түүхтэй. Манай түүхийн эх сурвалжуудад цэрэг дайчилгаа болон албан татвар хураах зорилгоор хүн амаа тоолдог байсан тухай тэмдэглэн үлдээсэн байдаг.

Монгол Улсын түүхийн холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, баримт материалд монголын хүн амын тооны талаар дурьдагдсан тоо баримт нь хоорондоо ихээхэн зөрүүтэй, албан ёсны эх сурвалж нь тодорхой бус явж ирсэн нь монголын түүхэн хүн ам зүйн судалгаанд нөлөөлсөн ажээ. Өөрөөр хэлвэл судалгааны эх бааз суурь болсон түүхэн албан эх сурвалж хомс байсан явдал болно. Монгол улсад нийт хүн амын толлого XX зууныг хүртэл явагдаж байгаагүй бөгөөд XX зууны анхны толлого 1918 онд явагдсан юм.

Монгол Улс XX зууны туршид 9 удаа (1918, 1935, 1944, 1956, 1963, 1969, 1979, 1989, 2000 онуудад) хүн амаа тоолсон байна. 1956 оны хүн амын тооллогыг статистикийн байгууллага явуулсан бөгөөд тэр үедээ аргачлал, хөтөлбөрийн хувьд нилээд боловсронгуй болсон байна. Тиймээс XX зууны Монголын түүхийн хувьд өмнөх үеэтэй харьцуулхад түүхэн хүн ам зүйн судалгаа хийх боломж, материалаг бааз бүрдэж иржээ. Гэвч энэ талаархи судалгаа шинжилгээний ажил маш хангалтгүй байгаа билээ. Эл байдал нь тус орон дахь түүхэн хүн зүйн ухааны хөгжлийг зохих түвшинд гаргах шаардлага байгааг илтгэнэ.

Abstract: In the article, the author introduced a brief history and comprehension of historical demography. The author highlighted relations and connections between demographic and historical researchs and discussed consensus of historical demography. Also brief introduction of Mongolian historical demography and current development and condition.